



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 01 сарын 17 өдөр

Дугаар А/14

Ховд

Газар эзэмших эрх шилжүүлэх тухай


Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.3, 38.4 дэх заалт, Хаягжуулалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 267 дугаар тогтоол, Жаргалант сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 143 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жаргалант сумын Магсаржав баг Амарсанаагийн 1 дүгээр гудамжны 112 тоотод байрлах, гэр бүлийн хэрэгцээний зориулалттай Ноосгойн Сүрэнжав /ПЮ51113013/-ын эзэмшлийн 1350.0 метр квадрат газраас газар эзэмших эрх шилжүүлэх гэрээний дагуу 1162 метр квадрат газрыг Адилбиш Цэр-Очир /ПЮ83121972/-т шилжүүлэн хаягийг Амарсанаагийн 1 дүгээр гудамжны 112 а тоот, болгон, худалдаа үйлчилгээний зориулалтаар 15 жилийн хугацаатайгаар, үлдсэн 188 метр квадрат газрыг Ноосгойн Сүрэнжав /ПЮ51113013/-д хаягийг Амарсанаагийн 1 дүгээр гудамжны 112 тоот болгон, гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 15 жилийн хугацаатайгаар тус тус эзэмшүүлсүгэй.

3. Газар эзэмших эрхийг хуулийн дагуу шилжүүлж газраа зориулалтын дагуу үр ашигтай, зүй зохистой эзэмшиж, ашиглаж, хамгаалж, газар эзэмшүүлэх гэрээнд заасан нөхцөл болзлыг биелүүлж ажиллахыг дээрх иргэнд үүрэг болгосугай.

4. Газар эзэмших эрх нь баталгаажсан иргэнтэй газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, газар эзэмших эрхийн гэрчилгээ олгон, газрын төлбөрийг хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэн гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Б.Баярсүх/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ